



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 671  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН АЙМГИЙН МОГОД  
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Могод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Рэгзэндаржаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021342

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Рэгзэндаржаа Могод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Рэгзэндаржаагийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Б.Рэгзэндаржаад

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН МОГОД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАТБААТАР ОВОГТОЙ РЭГЗЭНДАРЖААГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.07.23

СУМЫН ХӨГЖИЛ БАГААС ЭХЭЛНЭ

1. Бүх шатны сайд Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрийг дэмжиж хамтарч ажиллана.
2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа олгох чанарыг сайжруулна. Иргэн өөртөө эмч хөдөлгөөнийг өрнүүлж иргэний эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр арга хэмжээг дэмжиж хамтарч ажиллана
3. Малчдын хүүхдүүдийг нүүдлийн болон суурин цэцэрлэгт хамруулж сургуулийн өмнөх боловсролд 100 хувь хамруулахад анхаарч санаачлагатай ажиллана
4. Үндэсний спорт болох морин спорт, бөх, сур, шагайн харвааг нийтийн хүртээл болгон хөгжүүлэхэд хамтарч ажиллана
5. Язгуур урлаг болох уртын дуу, хөөмий, бие биелгээ, морин хуур зэрэг төрлүүдийг хөгжүүлж уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулж хэвшүүлэхэд хамтарч ажиллана
6. Ахмад үеэ хүндлэх, мэндлэх үндэсний ёс заншлыг залуучуудад түгээн дэлгэрүүлэхэд санаачлагатай ажиллана
7. Залуучуудын хөдөлмөр эрхлэх идэвх санаачлагыг дэмжиж шинэ ажлын байр бий болгох тал дээр онцгой анхаарч хамтарч ажиллана.
8. Түүх соёл байгалийн үзэсгэлэнт газрын нөөцөд тулгуураласан аялал жуулчлалыг хэрэгжүүлэхийг дэмжиж хамтарч ажиллана.

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:  
Булган аймгийн Могод сумын  
Баясгалант багийн иргэн  
Батбаатарын Рэгзэндаржаа  
ГЕ97110310...  
90831103